



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

___ оны __ сарын __ өдөр

Дугаар ___

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Татварын ерөнхий хуулийн 78 дугаар зүйлийн 78.7 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ
нь:

1. “Зөвлөмж авах хүсэлтэд тавигдах шаардлага, зөвлөмжийг олон нийтэд мэдээлэх, хүчингүй болгох журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Зөвлөмжийн авах хүсэлтийн маягтын загвар”-ыг 2 дугаар хавсралтаар, “Зөвлөмжийн маягтын загвар”-ыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Татварын ерөнхий газар /Б.Заяабал/-т үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Ганбат/-т даалгасугай.

Ч.ХҮРЭЛБААТАР

ЗӨВЛӨМЖ АВАХ ХҮСЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙГ ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Татварын ерөнхий хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.1, 78.1.2-д заасан татварын хууль тогтоомж хэрэгжүүлэх зөвлөмж /цаашид зөвлөмж гэх/ гаргах, олон нийтэд мэдээлэх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2.Татварын алба нь татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргын гаргасан зөвлөмжийг үйл ажиллагаандаа заавал дагаж мөрдөнө.

1.3.Зөвлөмжийг Татварын ерөнхий хууль, Захиргааны ерөнхий хууль, холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн гаргах бөгөөд зөвлөмжийн агуулга нь хууль тайлбарласан, захирамжилсан шинжийг агуулахгүй.

1.4.Зөвлөмжийг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар байгуулагдсан зөвлөмж авах хүсэлтийг шийдвэрлэх чиг үүрэг бүхий байнгын ажлын хэсэг /цаашид “ажлын хэсэг” гэх/ хууль тогтоомжийн хэрэгжилтийн судалгаанд үндэслэн гаргана.

Хоёр.Зөвлөмж авах хүсэлт гаргах, хүсэлтэд тавигдах шаардлага

2.1.Зөвлөмж авах хүсэлтийг татварын хууль тогтоомжийн дагуу татвар төлөх үүрэг бүхий этгээд, татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэг бүхий холбогдох төрийн байгууллага гаргаж болно.

2.2.Энэ журмын 2.1-д заасан этгээд нь зөвлөмж авах хүсэлт гаргах тохиолдолд “Зөвлөмж авах хүсэлтийн маягт”-ыг бөглөж, албан бичгийн хамт татварын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын даргад ирүүлнэ.

2.3.Зөвлөмж авах хүсэлт нь дараах шаардлагыг хангасан байна:

2.3.1.холбогдох хууль болон энэ журамд нийцсэн байх;

2.3.2.зөвлөмж авах хуулийн зүйл, заалтыг тодорхой тусгасан байх;

2.3.3.“Зөвлөмж авах хүсэлтийн маягт”-ыг үнэн зөв, бүрэн бөглөсөн байх;

2.3.4.хуулийн үзэл баримтлал, зүйл, хэсэг, заалт, дэд заалтын агуулгыг санаатайгаар мушгин гуйвуулсан, өөрт ашигтай байдлаар буруу хэрэглэх ойлголтыг хүсэлтэд дурдаагүй байх;

2.3.5.зөвлөмжийн хүсэлтэд тухайн зүйл, хэсэг, заалт, дэд заалтын хэрэгжилттэй холбоотой үүсч буй асуудлыг холбогдох жишээг баримт, нотолгоотой тусгасан байх;

2.3.6.зөвлөмжийн хүсэлтэд татварын хууль тогтоомжийн холбогдох заалтыг хэрэгжүүлэхэд үүссэн нөхцөл байдал, хуулийн үндэслэл, холбогдох жишээг тайлбарласан тайлбарыг нотлох баримтын хамт хавсаргах;

2.3.7.зөвлөмж авах хүсэлтийг татвар төлөгч өөрөө, эсхүл гүйцэтгэх удирдлага, итгэмжлэгдсэн төлөөлөгч гаргах.

Гурав.Зөвлөмж авах хүсэлтийг шийдвэрлэх

3.1.Ажлын хэсэг нь ирүүлсэн хүсэлтийг хянан энэ журмын 2.3-т заасан шаардлага хангаагүй тохиолдолд хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

3.2.Татварын ерөнхий хуулийн 78 дугаар зүйлийн 78.3-т зааснаас бусад тохиолдолд ажлын хэсэг нь хүсэлтийг хүлээн авна.

3.3. Ажлын хэсэг нь энэ журмын 2.3-т заасан шаардлагыг хангасан хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор судлах бөгөөд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл татварын улсын ерөнхий байцаагч уг хугацааг 1 удаа 30 хүртэл хоногоор сунгаж болно.

3.4.Зөвлөмжийн төсөл боловсруулсан ажлын хэсэг нь тухайн зөвлөмж авах хүсэлт ирүүлсэн этгээдээс зөвлөмжид туссан асуудлаар тодруулга, нэмэлт мэдээлэл гаргуулж болно.

3.5.Татварын улсын ерөнхий байцаагч нь энэ журмын 3.3-т заасан хугацаанд зөвлөмжийг хүсэлт гаргагчид хүргүүлнэ.

3.6.Татварын улсын ерөнхий байцаагч нь Татварын ерөнхий хуулийн 78 дугаар зүйлийн 78.3-т заасан нөхцөл үүссэн тохиолдолд хүсэлтийг хүлээн авахаас татгалзана. Татгалзсан тухай хариуг хүсэлт гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэнэ

Дөрөв.Зөвлөмжийг олон нийтэд мэдээлэх

4.1.Татварын хууль тогтоомжийг мөрдөх зөвлөмжийг гаргасан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор татварын албаны зөвлөмжийн цахим санд нийтэлнэ.

4.2.Татварын алба нь Татварын ерөнхий хуулийн 78 дугаар 78.2-т заасан олон нийтэд нээлттэй зөвлөмжийн цахим сантай байна.

4.3.Зөвлөмжийн цахим санг татварын албаны хэвлэл мэдээлэл хариуцсан нэгж хариуцан хөтөлнө.

4.4.Цахим санд нийтлэгдсэн өдрөөс хойш татварын албаны хэмжээнд зөвлөмжийг дагаж мөрдөнө.

Тав.Зөвлөмжийг хүчингүй болгох

5.1.Татварын улсын ерөнхий байцаагч, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь дараах тохиолдолд зөвлөмжийг бүрэн буюу хэсэгчлэн хүчингүй болгоно.

5.1.1.зөвлөмж нь хуульд заасан шаардлага хангаагүй бол;

5.1.2.татварын ерөнхий хуулийн 78 дугаар зүйлийн 78.5-д заасан нөхцөл үүссэн тохиолдолд.

5.2.Зөвлөмжийг хүчингүй болгосон тухай энэ журмын 4.1-д заасны дагуу олон нийтэд мэддээлнэ.



Монголын Татварын Алба

Маягт 3-01

ЗӨВЛӨМЖ АВАХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ

..... оны сарын өдөр

Дугаар:

1. Хүсэлт гаргагчийн нэр:
2. ТТД:
3. Хаяг, утас, цахим хаяг:
4. Зөвлөмж авах хуулийн нэр, батлагдсан огноо, хуулийн зүйл, хэсэг, заалт, дэд заалтын дугаар:
.....
.....
5. Зөвлөмж авах асуулт:
.....
.....
.....
.....
.....
.....
.....
6. Хуулийг хэрхэн хэрэгжүүлэх талаарх хүсэлт гаргагчийн байр суурь, хуулийн үндэслэлийн талаарх тайлбар, холбогдох жишээ:
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

Зөвлөмж авахаар хүсэлт гаргасан:

Хүсэлтийн хүлээж авсан:



Монголын Татварын Алба

Маягт 3-01

ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ЗӨВЛӨМЖ

..... оны сарын өдөр

Дугаар:

Судалгаа, санал дүгнэлт:

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

Зөвлөмж болгох нь:

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

ГАРЫН ҮСЭГ: